



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал”-ыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /С.Бүрэнбат/-г үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



Монгол Улсын Ерөнхий аудиторовн
2020 оны 6 дугаар сарын 16 -ны
өдрийн 4/56 дугаар тушаалын
хавсралт

9006109
9019120396

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛ БОЛОН БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Төрийн аудитын байгууллага Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай (цаашид АНСДИТХСТ гэх) хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, АНСДИТХСТ хуульд нийцсэн эсэх, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянаж, дүгнэлт гаргахад энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Төрийн аудитын байгууллага энэхүү аудитыг хийхдээ MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг баримтлан ажиллана.

1.3. АНСДИТХСТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.6-д зааснаар нам, эвсэл нь ээлжит сонгуулийн жилийн 6 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 7 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад ирүүлэх ба аудитын баг АНСДИТХСТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.9, 37.10, 37.11-т заасан хугацаанд дүгнэлт гаргана.

Хоёр. Аудитын үе шатны ажлыг хэрэгжүүлэх аргачлал

2.1. Төрийн аудитын байгууллагаас нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт хийх нийцлийн аудит нь дараах үе шаттай байна. Үүнд:

- 2.1.1. аудитыг төлөвлөхийн өмнөх үе шат;
- 2.1.2. аудитыг төлөвлөх үе шат;
- 2.1.3. аудитыг гүйцэтгэх үе шат;
- 2.1.4. аудитын дүгнэлт гаргах үе шат.

Аудитыг төлөвлөхийн өмнөх үе шат

2.2. Аудитыг төлөвлөхийн өмнөх үе шатанд аудитын багийг томилох, урьдчилсан судалгаа хийж ойлголттой болох, аудитын ажлын нөхцөлийг нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчид танилцуулах ажлыг хэрэгжүүлнэ.

2.3. Томилогдсон аудитын багийн гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй талаарх мэдэгдэл тайлбар болон нууцын баталгааг гаргуулж баталгаажуулна.

2.4. Аудитын баг дараах эрх зүйн баримт бичгүүдийг судалсан байна. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- “Алсын хараа-2050”;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;



- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагатай холбоотой бусад эрх зүйн баримт бичгүүд;
- Өмнөх аудитын архивын баримт материалууд;
- Холбогдох бусад хууль, тогтоомж, баримт бичиг.

2.5. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид аудитын ажлын нөхцөлийг танилцуулах аудитын ажлын захидлыг илгээнэ. Ажлын захидлын загварыг энэхүү аргачлалын 1 дүгээр хавсралтын загвар маягтуудын дагуу бэлтгэн улс төрийн нам, эвсэлд хүргүүлнэ. Аудитын баг шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл гаргуулах хавсралт боловсруулж, ажлын захидалд нэмж хавсаргаж болно.

2.6. Бие даан нэр дэвшигчид аудитын ажлын захидлыг сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлэх үед гардуулахаар бэлтгэсэн байна.

Аудитын төлөвлөлтийн үе шат

2.7. Аудитын баг аудитыг төлөвлөхдөө дараах үе шатны ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.7.1. аудитын эрсдэлтэй асуудлыг тодорхойлж, эрсдэлийг үнэлж баримтжуулах;
- 2.7.2. аудитын материаллаг байдлын түвшин тодорхойлох;
- 2.7.3. аудитын горим, сорилыг боловсруулж хэрэгжүүлэх арга зүйг тодорхойлох;
- 2.7.4. Аудитын төлөвлөгөөг боловсруулж батлуулах.

Эрсдэлтэй асуудлыг тодорхойлж, эрсдэлийг үнэлж баримтжуулах

2.8. Аудитын эрсдэлтэй асуудлыг тодорхойлохын тулд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулахдаа холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж ирүүлээгүй байж болох эрсдэлийг авч үзнэ.

2.9. Аудитын баг аудитын турш шаардлагатай тохиолдол бүрд эрсдэлийг үнэлж, аудитын горимуудыг гүйцэтгэнэ. Аудитын эрсдэлд дараах асуудлууд хамаарч болох юм.

- 2.9.1. нам, эвсэл, бие даан нэр дэвшигч Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нийцүүлэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээгээ боловсруулсан эсэх;
- 2.9.2. нам, эвсэл, бие даан нэр дэвшигч “Алсын хараа-2050” -д нийцүүлэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээгээ боловсруулсан эсэх;
- 2.9.3. нам, эвсэл, бие даан нэр дэвшигч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагатай холбоотой бусад эрх зүйн баримт бичгүүдтэй нийцүүлэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээгээ боловсруулсан эсэх;
- 2.9.4. мөрийн хөтөлбөрт холбогдох хуулиудад нийцээгүй зорилт, арга хэмжээг далд агуулгаар тусгасан эсэх;
- 2.9.5. аудитын явцад гарч болох бусад эрсдэлтэй асуудлууд байгаа эсэх.

2.10. Энэхүү аргачлалын 3 дугаар хавсралтын дагуу эрсдэлийг үнэлж, төлөвлөгөөний хавсралтаар баримтжуулсан байна.

Материаллаг байдлын түвшин тодорхойлох

2.11. Аудитын баг материаллаг байдлыг тоон болон чанарын хүчин зүйлээр авч үзнэ. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр нь үзүүлэх үр дагавар их, олон нийтийн анхаарал татах магадлал их учраас материаллаг байдлын түвшин хамгийн бага байхаар төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд үнэлнэ.

2.12. Аудитын гүйцэтгэлийн үе шатанд нотлох зүйлийг үнэлэх үед мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний аль нэг заалт холбогдох хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийн нэг болон түүнээс дээш заалттай нийцэхгүй байвал материаллаг гэж үзнэ.



Аудитын төлөвлөгөөг боловсруулж батлуулах

2.13. Аудитын баг аудитыг АНСДИТХСТ хуульд заасан богино хугацаанд чанартай гүйцэтгэхээр төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулна.

2.14. Аудитын төлөвлөгөө нь аудитад хяналт тавих гол баримт бичиг бөгөөд аудитын зорилго, зорилт, хамрах хүрээ, аудитын эрсдэл, аудитад ашиглах арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа, аудитыг гүйцэтгэх багийн гишүүд, аудитын төсөв зэргийг тусгасан төлөвлөгөөг аудитын баг боловсруулж, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитораар батлуулна. Аудитын төлөвлөгөөний загварыг энэхүү аргачлалын 2 дугаар хавсралтын дагуу боловсруулна.

Аудитын горим, сорилыг боловсруулж хэрэгжүүлэх арга зүйг тодорхойлох

2.15. Аудитын баг илрүүлэлтийн эрсдэлийг хамгийн бага байлгахаар мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ тус бүрийг шалгах дэлгэрэнгүй горим, сорилыг төлөвлөж хэрэгжүүлнэ.

2.16. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ бүрд дэлгэрэнгүй горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн үе шатанд ажлын баримтын маягт зааврыг боловсруулна.

2.17. Ажлын баримтын маягт (шалгах хуудас)-ыг энэхүү аргачлалын 4, 5 дугаар хавсралт маягтуудын дагуу боловсруулна.

Аудитыг гүйцэтгэх үе шат

2.18. Аудитыг гүйцэтгэхдээ юуны өмнө сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг хүлээн авах бэлтгэлийг хангасан байна. Хүлээн авах аудитын багийн гишүүдийг томилсон байх бөгөөд мөрийн хөтөлбөрийг тусгайлсан битүүмжлэлтэй газар хадгална.

2.19. Нам, эвслийн болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг албаны нууцын зэрэглэлийн түвшинд адилтган авч үзэж, аудитын багийн гишүүд нууцыг чандлан хадгална.

2.20. Тухайн нэгжийн тэргүүлэх аудитор, аудитын менежер нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавина.

2.21. Аудитыг гүйцэтгэхдээ дүгнэлт гарахад дэмжлэг үзүүлэх нотлох зүйлсийг цуглуулах, бүрдүүлэх, тэдгээрийг үнэлэх, дүн шинжилгээ хийж батлагдсан төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэнэ.

2.22. Аудитыг гүйцэтгэх үе шатанд дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

- 2.22.1. аудитын горимуудыг хэрэгжүүлэх;
- 2.22.2. аудитын нотлох зүйлсийг цуглуулах;
- 2.22.3. аудитын нотлох зүйлсийг үнэлэх;
- 2.22.4. дүгнэлт гаргах;
- 2.22.5. баримтжуулалт хийх.

2.23. Аудитор нам, эвсэл, бие даан нэр дэвшигч тус бүрд энэхүү аргачлалын 4, 5, дугаар хавсралтаар батлагдсан маягтууд, шалгах хуудсыг ашиглан дүгнэлт гаргах ажлын баримтыг бүрдүүлсэн байна.

2.24. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ тус бүрийг АНСДИТХСТ хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан хориглосон арга хэмжээ байгаа эсэхийг энэхүү аргачлалын 4 дүгээр хавсралтын дагуу шалгана.



2.25. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний материаллаг бөгөөд эрсдэлтэй асуудлыг сонгон энэхүү аргачлалын 4, 5 дугаар хавсралтаар батлагдсан ажлын баримтыг бүрдүүлнэ.

2.26. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ ойлгомжгүй томъёологдсон, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй бол холбогдох албан тушаалтан болон хүмүүстэй ярилцлага хийх, тодруулга хийх, нэмэлт баримт материал гаргуулах, асуулга авах, ажиглалт хийх зэрэг бусад нотлох зүйл цуглуулах арга зүйг хэрэгжүүлнэ.

2.27. Аудитын өдөр тутмын чанарын хяналтыг аудитын менежер, тэргүүлэх аудитор нар Чанарын хяналтын журмын дагуу хэрэгжүүлнэ.

Аудитын дүгнэлт гаргах

2.28. Аудитын илрүүлэлт ба материаллаг байдал дээр үндэслэн аудитор нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр бүх материаллаг байдлын хувьд холбогдох шалгууртай нийцэж байгаа эсэхийг үнэлж, дүгнэнэ.

2.29. Аудитын дүгнэлт гаргах үе шатанд дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

2.29.1. аудитын үр дүнг нэгтгэнэ;

2.29.2. материаллаг байдлыг дахин авч үзнэ;

2.29.3. аудитын шалгууртай харьцуулан дүгнэлт гаргана.

2.30. Хэрэв материаллаг зөрчил илэрвэл тэдгээрийг бүлэглэн нэгтгэж Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу шаардлага хангаагүй гэсэн дүгнэлтийг гаргаж, нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчид тав хоногийн дотор уг зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин ирүүлэхээр хүргүүлнэ. Энэхүү дүгнэлтийг аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор баталгаажуулна.

2.31. Хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлтийг энэхүү аргачлалын 6 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргаж хүргүүлнэ.


2.32. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр материаллаг байдлын хувьд холбогдох хуульд заасан шаардлагатай нийцэж байвал зөрчилгүй дүгнэлтийг гаргана. Дүгнэлтийг Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор баталгаажуулна. Зөрчилгүй санал дүгнэлтийг энэхүү аргачлалын 7 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу гаргаж хүргүүлнэ.

2.33. Аудитын баг тухайн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн, үл нийцсэн талаар дүгнэлт гаргасан үндэслэлийг холбогдох нам, эвслийн эрх бүхий албан тушаалтан, бие даан нэр дэвшигчид танилцуулна.

2.34. Гаргасан дүгнэлтийг Аймаг, Нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10, 37.11-д заасны дагуу тойргийн Сонгуулийн хороонд хүргүүлнэ.

2.35. Аудитын баг нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн дүгнэлт гаргасан сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд өгсөн аудитын эцсийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанд цахим хуудаст нээлттэйгээр байршуулна.

2.36. Аудитын баг холбогдох бүх ажлын баримт материал, нотлох зүйлсийг иж бүрэн, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу нэгтгэж, архивын нэгж болгон бэлтгэж Төрийн аудитын байгууллагын архивд хүлээлгэн өгнө.



Монгол Улсын Ерөнхий аудиторовн
2020 оны 156 дугаар тушаалаар батлагдсан
аргачлалын нэгдүгээр хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЛИЙН УДИРДЛАГА ТАНАА

Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах аудитын тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д “Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх...”-ийг Төрийн аудитын байгууллага хянаж, дүгнэлт гаргахаар заасан. Энэхүү зохицуулалтын дагуу сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрт аудит хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

1. Бид аудитыг Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд MNS 6817 : 2020 - Төрийн аудитын стандартын дагуу гүйцэтгэх ба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.1. Улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон заалт байгаа эсэхийг хянах;
- 1.2. Улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянах;
- 1.3. Мөрийн хөтөлбөрийн санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар хянах;
- 1.4. Тодруулах зүйлсийг тухай бүр мэдэгдэх бөгөөд аудитын явцад удирдлагаас нэмэлт мэдээлэл, тайлбар авах;
- 1.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргах болон дээрхтэй холбоотой бусад чиг үүрэг хамаарна.

Нам, эвслээс ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нийцэж байгаа эсэх дүгнэлтийг хуулийн хугацаанд тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу нам, эвслийн удирдлага дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- 2.1. Нам, эвсэл нь мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлсэн байхыг /Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37.6/;
- 2.2. Нам, эвсэл нь сонгуульд оролцох хүсэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө илэрхийлэхдээ дээрх дүгнэлтийг гаргуулсан байхыг /Аймаг,



нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйл, мөн зүйлийн 25.3.4, 25.4.4/;

2.3. Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл /энэхүү захидлын нэг ба хоёрдугаар хавсралт/ мөн мөрийн хөтөлбөрийн 4 эх хувийг¹ хэвлэмэл байдлаар, хувийг CD -нд буулган албан бичгээр дугтуйнд хийж битүүмжлэлтэйгээр тоот/-д ажлын цагаар хүлээлгэн өгнө. Дугтуйн дээр нам, эвслийн нэрийг гаргацтайгаар бичсэн байна. /хэрэв эвсэл бол хуульд заасан журмын дагуу эвсэл байгуулагдсан талаарх нотлох баримтын хамт./

Аудит гүйцэтгэх хугацаанд сонгуульд оролцох нам, эвсэл дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих мөрийн хөтөлбөрийг шаардлагатай баримт, материалын хамт ирүүлэх, аудитын зорилгоор хүссэн нэмэлт тайлбар, мэдээллийг бичгээр баталгаажуулж өгөх, аудитын нотолгоог олж авах нөхцөл, боломжоор хангаж ажиллана уу.

Нам, эвсэл нь хуулийн дээрх зохицуулалтуудыг анхаарч мөрийн хөтөлбөрөө хуулийн хугацаанд ирүүлэх бөгөөд тус чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тухайн нам, эвслийг төлөөлөн шууд харилцах эрх бүхий албан тушаалтны мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлж, уг албан тушаалтан солигдох өөрчлөгдөх бүрд Төрийн аудитын байгууллагад албан бичгээр мэдэгдэж ажиллахыг хүсье.

Аудитыг хуулиар тогтоосон хугацаанд гүйцэтгэхэд харилцан хүлээсэн үүргээ хэрэгжүүлж хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Хавсралт.....хуудастай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

ХЯНАСАН:


АУДИТЫН МЕНЕЖЕР /гарын үсгийн тайлал/

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

АУДИТОР /гарын үсгийн тайлал/

¹ Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргасан тайланг эх хувиар 4 газар хэрэглэнэ. 1% -ийг ТАБ-д, 1% -ийг СХ-нд, 2% -ийг нам эвсэл, бие даан нэр дэвшигчид баталгаажуулан хүргүүлнэ.



Монгол Улсын Ерөнхий аудитор
 2020 оны 5 дугаар тушаалаар батлагдс...
 аргачлалын нэгдүгээр хавсралт (маягт А)

..... аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын 2020 оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан улс төрийн нам, эвслээс мөрийн хөтөлбөрийн хавсралтаар ирүүлэх мэдээлэл

№	Нам эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөллийг баримталсан эсэх (тийм, үгүй)	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн аль заалтад хамаарч буй	УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" -н аль заалтад хамаарч буй, мөн аймаг, нийслэлийг хөгжүүлэх зорилтын (холбогдох заалтыг бичих)	Тайлбар
1		2	3	4	5

Жич:

- 2 дугаар баганад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцоолохдоо төсвийн төсөөллийг баримталсан эсэх (2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Монгол улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль)
- 4 дүгээр баганад Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын аль заалтыг үндэслэл болгосныг тодорхой бичнэ.

Мэдээллийг бэлтгэсэн _____ -ЫГ ТӨЛӨӨЛЖ

Нам/эвслийн/нэр _____ -ЫГ ТӨЛӨӨЛЖ

(тэмдэг) _____ гарын үсэг

албан тушаал овог нэр _____ гарын үсэг

(тэмдэг) _____ -ЫГ ТӨЛӨӨЛЖ

албан тушаал овог нэр _____ гарын үсэг

2020 оны ... сарын ... өдөр




Монгол Улсын Ерөнхий аудитор
 2020 оны 9/56 дугаар тушаалаар батлагдс:
 аргачлалын нэгдүгээр хавсралт (маягт)

..... аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын 2020
 оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар
 албан бичгийн хоёрдугаар хавсралт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардлагатай зорилт, арга хэмжээний жагсаалт

№	Нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ	Шаардагдах зардлын нийт (сая төгрөгөөр)	Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр болон зардлын дүн /он тус бүрээр/												Тайлбар												
			2021				2022				2023					2024											
			Үлсын болон орон нутгийн төсөв	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр, тусламж	Үлсын болон орон нутгийн төсөв	Гадаадын зээл	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр, тусламж	Үлсын болон орон нутгийн төсөв	Гадаадын зээл		Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр, тусламж									
1		2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27
			Үлсын болон орон нутгийн төсөв	Гадаадын зээл	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр, тусламж		Үлсын болон орон нутгийн төсөв	Гадаадын зээл	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр, тусламж		Үлсын болон орон нутгийн төсөв	Гадаадын зээл	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр, тусламж		Үлсын болон орон нутгийн төсөв	Гадаадын зээл	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр, тусламж		

Мэдээллийг бэлтгэсэн _____ -ыг төлөөлж
 Нам/эвслийн/нэр
 (тэмдэг) _____ -ыг төлөөлж
 албан тушаал овог нэр гарын үсэг
 (тэмдэг) _____ -ыг төлөөлж
 албан тушаал овог нэр гарын үсэг
 2020 оны ... сарын ... өдөр



(Гарын үсэг, тайлал)

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

20... оны ээлжит Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах

2. Аудитын код

(Аудитын кодыг оруулах)

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" -д нийцсэн эсэхэд дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа-2050" -д нийцсэн эсэх;
- Мөрийн хөтөлбөрийн зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан хориглолттой холбоотой асуудлыг тусгасан эсэх;
- Монгол Улсын төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх;

5. Аудитын хамрах хүрээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгаа болон холбогдох бусад баримт материалыг авч үзнэ.



6. Үндсэн мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан зүйлүүдийг мөрийн хөтөлбөртөө тусгахыг хориглосон байна.

Нам, эвсэл нь мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар 6 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигч нь 7 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Нам, эвсэл нь сонгуульд оролцох хүсэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө, бие даан нэр дэвшигч нь сонгуульд оролцох хүсэлтийг санал авах өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулсан байна.

7. Аудитыг төлөвлөх үеийн материаллаг байдлын түвшин

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр нь үзүүлэх үр дагавар их, олон нийтийн анхаарал татах магадлал их учраас материаллаг байдлын түвшинг чанарын үзүүлэлтэд илүү анхаарал хандуулах нь зохимжтой гэж үзэв.

8. Эрсдэлийн үнэлгээ

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “.....” гэж үзлээ.

9. Аудитын арга зүй

Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд MNS 6817 : 2020 - Төрийн аудитын стандартын дагуу гүйцэтгэнэ.

10. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”;
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эх сурвалж.

11. Аудитын хугацаа

Аудитыг 20.... оны дугаар сарын-нд эхэлж, дүгнэлтийг 20.... оны дүгээр сарын-нд дуусгаж, Тойргийн сонгуулийн хороо болон холбогдох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд хүргүүлнэ.

12. Аудитын хөтөлбөр:



(Жишээ нь: Аудитын хөтөлбөрийг энэхүү төлөвлөгөөний хавсралтад үзүүлэв г.м.)

13. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

- Аудитын явцыг хянан удирдах ажилтан:
- Аудит хийх аудиторүүд:
- Аудитад оролцох гадны шинжээч, мэргэжилтэн: Г.М.

13. Аудитад шаардагдах хөрөнгө нөөц

а. Боловсон хүчин: хүн/ өдөр

б. Санхүүгийн нөөц, бүгд: мян.төг.

Үүнээс:

- цалин хөлс мян.төг.
- дотоод томилолт..... мян.төг.
- гадаад томилолт..... мян.төг.
- тээврийн зардал..... мян.төг.
- бусад мян.төг.

в. Техник, хэрэгсэл: (компьютер, принтер, диктафон, гэрэл зургийн аппарат, видео камер, хувилагч г.м.)

г. Бусад: (мэдээллийн сан г.м.)



Аудитын эрсдэлийн үнэлгээ

Эрсдэл	Магадлал (Их/Дунд/Бага)	Үр дагавар (Их/Дунд/Бага)	Үнэлгээ (Их/Дунд/Бага)
Ерөнхий үнэлгээ			



Монгол Улсын Ерөнхий аудито
 А/56 дугаар тусгаар тусгаалаар батлагдсан
 аргачлалын дөрөвдүгээр хавсралт

Аудитын код _____


Нам, эвслийн нэр _____

..... оны сарын өдөр

Ажлын баримтын дугаар _____

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь **Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт нийцэж буй эсэхийг шалгах хуудас**

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т нийцсэн эсэх (Тийм/ Үгүй)					Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон асуудал
Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ	Мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбоотой эрх олгох	Уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлого, түүнчлэн улс, орон нутгийн төсвөөс иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх	Зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх	Иргэдэд үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх	Ажлын байранд зуучлах, ажилд оруулах	



Монгол Улсын Ерөнхий аудит
 А/Б дугаар тушаалаар батлагдсан
 аргачлалын тавдугаар хавсралт

Аудитын код _____


Нам, эвслийн нэр _____

..... оны сарын өдөр

Ажлын баримтын дугаар _____

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ “Алсын хараа-2050”-д нийцэж буй эсэхийг шалгах хуудас

	Зорилт, арга хэмжээ	Нийцээгүй заалт	Тайлбар
1.		-	
2.		-	
3.		-	
4.		-	
5.		-	
6.		-	
7.		-	
8.		-	



..... /АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ/-ИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ НАМ, ЭВСЛИЙН
ДАРГА ТАНАА
/БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ТАНАА/

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлага хангаагүй талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох (нам, эвслийн нэр)-ын /бие даан нэр дэвшигч иргэн (овог, нэр)/-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох (нам, эвслийн нэр)-ын /бие даан нэр дэвшигч иргэн (овог, нэр)/-ийн “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-т Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн аудит хийхэд хуульд нийцээгүй, эдийн засгийн үндэслэл тооцоо судалгаагүй зорилт, арга хэмжээ



тусгасан нь хууль тогтоомжийн холбогдох шаардлагад нийцсэн гэх дүгнэлт гаргах боломжгүй байна.

Энэхүү дүгнэлтийн нэгдүгээр хавсралтаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт нийцээгүй зорилт, арга хэмжээний жагсаалтыг, хоёрдугаар хавсралтаар “Алсын хараа-2050”-д нийцээгүй зорилт, арга хэмжээний жагсаалтыг, гуравдугаар хавсралтаар санхүүжилтийн эх үүсвэр, зардлын дүн шаардлагатай зорилт, арга хэмжээний жагсаалтыг хүргүүлэв.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар ирүүлэх боломжтой.

Хавсралт хуудастай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР /гарын үсгийн тайлал/

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

АУДИТОР /гарын үсгийн тайлал/



Монгол Улсын Ерөнхий аудиторовын
 2020 оны 9/56 дугаар тушаалаар батлагдсан
 аргачлалын долоодугаар хавсралт

..... /АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ/-ИЙН
 ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
 ОРОЛЦОХ НАМ ЭВСЭЛД

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
 ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох (нам, эвслийн нэр)-ын /бие даан нэр дэвшигч иргэн (овог, нэр)-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

“.....нам/эвсэл болон бие даан нэр дэвшигч”- ийн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“..... нам/эвсэл болон бие даан нэр дэвшигч”- ийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.



Хувийг: /тухайн шатны/ Сонгуулийн хороонд
Хавсралт хуудастай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР /гарын үсгийн тайлал/

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР /гарын үсгийн тайлал/

АУДИТОР /гарын үсгийн тайлал/